



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/161

Хэрлэн сум

**Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
худалдан авах ажиллагааг зохион байгуулах
үнэлгээний хороо байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.3, 50.4, 50.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих Мөрөн сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга угсралт, Хэнтий аймгийн цагдаагийн газрын өргөтгөлийн барилгын их засвар, Өмнөдэлгэр сумын болон Хэрлэн-Баян Улаан тосгоны Цаг уурын өртөөний барилгын их засварын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---------------|---------------|--|
| Дарга: | Г.Лхагвахатан | Орон нутгийн өмчийн газрын дарга |
| Нарийн бичиг: | Н.Үнэнбат | Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Гишүүд: | М.Хишигбаяр | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилга хот байгуулалтын хэлтсийн дарга |
| | Ж.Даваасүрэн | Төрийн бус байгууллагын төлөөлөл |
| | Д.Оюун | Төрийн бус байгууллагын төлөөлөл |

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ